



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/519

Булган

### Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.7, 32.1.8 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2018 онд байгуулсан үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний дагуу Булган аймагт 2018 оны 09 дүгээр сард зохион байгуулагдах "Гамшгаас хамгаалах команд штабын сургууль"-ийн бэлтгэл ажлыг хангах "Ажлын хэсэг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Сургуулийн бэлтгэл ажлын удирдагч:

- Аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий

Сургуулийн бэлтгэл ажлын удирдагчийн орлогч:

- Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Ш.Баасандорж
- Гамшгаас хамгаалах албадын гамшгаас хамгаалах ажил хариуцсан мэргэжилтэн

Гамшгаас хамгаалах төлөвлөлт хариуцсан ажилтан:

- Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэд хурандаа Н.Хишигдорж
- Гамшгаас хамгаалах албадын штабын дарга нар

Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах ажил хариуцсан ажилтан:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Даргын ажлын болон шийдвэрийн зураг хариуцсан ажилтан:

- Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, ажилтан
- Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах дуурайлган үзүүлэх дадлага сургуулийг удирдах ажилтан:

- Гал түймэр унтраах, аврах анги, салбарын захирагч
- Гамшгаас хамгаалах албадын мэргэжлийн ангийн дарга

Холбоо, зарлан мэдээллийн ажилтан:

- Холбоо, зарлан мэдээллийн албаны дарга
- Онцгой байдлын газрын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд



Хээрийн удирдлагын байр, удирдах ажилтны бие, бялдар, сэтгэл зүйн сорил дадлага хариуцсан удирдах ажилтан:

- Эрүүл мэндийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн алба, Байгаль орчны алба, Эрчим хүчний алба, Ус дулаанаар хангах алба, Цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх албаны дарга нар
- Булган сумын Засаг дарга

Сургуулийн үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан:

- АЗДТГ-ын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Барилга, хот байгуулалтын алба, Мэргэжлийн хяналтын албаны дарга нар
- Онцгой байдлын газрын техник хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Санхүү, хангалт хариуцсан ажилтан:

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Сургалт, сурталчилгааны ажилтан:

- Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн хэвлэл мэдээллийн албаны дарга
- Онцгой байдлын газрын ангиллын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Зураглаач-оператор:

- Сурталчилгаа мэдээллийн албаны дарга
- Гамшгаас хамгаалах албадын штабын чиглэл хариуцсан туслахууд

Бичээч, баримт хөтлөгч:

- Аймгийн ЗДТГ, Булган сумын ЗДТГ, Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах албадын бичиг хэрэг, архивын эрхлэгч


2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн "Гамшгаас хамгаалах команд штабын сургууль"-ийн бэлтгэл ажлыг төлөвлөгөө, "Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах зааврын дагуу хангуулж, тайлан мэдээг нэгтгэн, сургууль дадлагыг Улсын онцгой комисс болон Онцгой байдлын ерөнхий газрын ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулж, үр дүнг тооцон танилцуулахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З. БАТЗОРИГ

Аймгийн засаг даргын 2018 оны  
09 сарын 05 өдрийн 1/19 тоот  
захирамжийн хавсралт



"Гамшгаас хамгаалах команд штабын сургууль"-ийн зардал

№	Зориулалт	дүн /төгрөгөөр/
1	Бичиг хэргийн зардал	1 902000
2	Шуудан холбооны зардал	575000
3	Шатахууны зардал	5490000
4	Сургалтын зардал	8960000
5	Хэвлэл мэдээллийн зардал	1418000
6	Удирдах бүрэлдэхүүний бие бялдар сэтгэл зүйн сорил дадлага	1620000
7	Тоног төхөөрөмж, сэлбэгийн зардал	2975000
8	Бусад зардал	2060000
<b>НИЙТ ДҮН</b>		<b>25000000</b>